2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,926,451.00	1,396,361.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,926,451.00	1,396,361.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,314,698.90	36,988,923.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,314,698.90	20,878,923.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	16,110,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,788,755.00	303,477,473.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,856,300.00	286,501,217.46
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	54,065,800.00	43,139,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	48,790,500.00	29,016,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		214,344,517.46
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,932,455.00	16,976,256.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	3,932,455.00	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		16,956,256.00
213503	Нэмэлт санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		20,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		5,996,000.00
222001	Тоног төхөөрөмж		5,996,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	189,145,757.90	601,279,233.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	189,145,757.90	601,279,233.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	41,518,105.00	30,004,455.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,272,069.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	137,644,583.90	324,490,170.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,711,000.00	23,926,908.00
131106	Эрүүл мэндийн датагалын сангийн нэмэлт орлого		222,857,700.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		20,168,701.54
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		20,168,701.54

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад орлогын бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01/34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлан нь Монгол улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан биелүүлж, иргэддээ төрийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх, иргэдээ аюулгүй тав тухтай орчинд амьдрах, сурч боловсрох нөхцөлөөр хангасан, жижиг дунд үйлдвэрт түшиглэсэн тогтвортой ажлын байр, орлогыг бий болгосон, байгалийн баялгийн үр өгөөжийг тэгш хүртэх боломжоор хангаж, улсын хөгжлийн загвар сум болох эрхэм зорилготой байгууллага байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлан нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан журмыг баримтлан сумын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж байна. Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/33 тоот захирамжаар ажлын хэсэг, журмаа батлуулан сумын дотоод хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг зохион байгуулсан байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас Заамар сумын "Заамар нутгийн хөгжлийг дэмжих сан"-ийн 2018-2021 оны эхний 9 сарын санхүүгийн үйл ажиллагаанд Төв аймгийн Засаг дарга бөгөөд Дотоод аудитын хорооны даргын баталсан 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 33/36 тоот удирдамжийн дагуу санхүүгийн хяналт

шалгалт хийгдэж, шалгалтаар 96,794.5 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг бүртгэлд тусгаагүй гэсэн 2 албан шаардлага өгөгдсөн байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 5,075,040.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 76,125.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 53,287.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцож үзэхэд гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 138,959.8 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 62,834.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг түвшинг дахин тооцов.

Учир нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон нийт орлого 5,075,040.5 мянган төгрөг гүйцэтгэлийн үе шатны орлого 9,263,985.5 мянган төгрөг, 4,188,945.0 мянган төгрөгөөр орлого нэмэгдсэн байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 8 төсөвт байгууллага, төрийн сан, сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, эм эргэлтийн сан, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 13 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

Орлогын талаар:

Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 185,495.7 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилт 3,137,834.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 69,027.2 мянган төгрөг, Орон нутгийн

хөгжлийн сангийн сангийн санхүүжилт 295,338.7 мянган төгрөг, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 127,780.4 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн орлого 64,507.9 мянган төгрөг, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн 58,857.4 мянган төгрөг, Шижир алтны цэцэрлэг 969.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 601,279.2 мянган төгрөг, орон нутгийн төсвийн орлого 897,728.9 мянган төгрөг, нийт 5,438,818.8 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг мөнгөн гүйлгээний тайлангаар төвлөрүүлэн зарцуулсан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлогыг хоорондын тооцоогоор устгал хийсэн байна.

Төв аймгийн Заамар сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн орон нутгийн төсөв батлах тухай 5 дугаар тогтоолд зааснаар Заамар сумын Засаг дарга тайлант онд 806,454.9 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан байна.

Төв аймгийн Заамар сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн орон нутгийн төсөв тодотгон батлах тухай 02 дугаар тогтоолд орон нутгийн төсвийн орлого 806,454.9 мянган төгрөгт өөрчлөлт оруулаагүй байна.

Заамар сумын Засаг дарга тайлант онд 806,454.9 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсныг гүйцэтгэлээр 879,728.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 111.3 хувиар биелүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга тайлант онд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 11,387,544.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 14,584,432.5 мянган төгрөг болж, 3,196,888.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга тайлант онд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 27,209.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 5,697.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 4,660.7 мянган төгрөгийн ном, 171.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө нийт 37,739.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авчээ.

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга тайлант онд 2,489,135.6 мянган төгрөгийн барилга байгууламж, 135,300.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 177,664.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 124,634.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 3,903.6 мянган төгрөгийн ном, 266,292.9 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нийт 3,196,930.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Авлага дансны эхний үлдэгдэл 328,849.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 562,551.6 мянган төгрөг болж 233,702.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Авлагын үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангийн 258,703.4 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага 45.98 хувийг, Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 285,745.7 мянган төгрөг 50,79 хувийг эзэлж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 373,325.0 мянган төгрөг, хүмүүсээс авах 176,076.1 мянган төгрөг, зээлийн хүүгийн авлага 13,150.4 мянган төгрөг нийт 562,551.6 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн. Үүнд: ЗДТГ 16,794.1 мянган төгрөг, Сум хөгжүүлэх сангийн 69,476.9 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 1,308.4 мянган төгрөг, Эмнэлгийн 285,745.7 мянган төгрөгийн авлага байна.

Өглөгийн үлдэгдлээр байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн өглөг 145,419.3 мянган төгрөг, орон нутгийн ерөнхий орлого 16,794.1 мянган төгрөг, нийт 162,213.4 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 120,424.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 162,213.5 мянган төгрөг болж, 41,788.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа сангийн өглөг 145,419.3 мянган төгрөгийн өглөг 89,64 хувийг эзэлж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 1,010,994.0 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд эмийн эргэлтийн сангийн 27,765.6 мянган төгрөг, нийт 1,038,759.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Төрийн сангийн харилцах дансанд орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 182,312.8 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 463,483.6 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 118,493.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн үлдэгдэл 34,968.8 мянган төгрөг, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн 191,566.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд Эрүүл мэндийн төвийн 20,168.7 мянган төгрөг байршиж байна.

Бараа материал 541,003.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 11,786,009.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,305,914.9	1,038,759.6	-267,155.3
Авлага	328,849.6	562,551.6	233,702.0
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	438,134.4	541,003.3	102,868.9
Үндсэн хөрөнгө	9,188,475.8	11,786,009.6	2,597,533.8
Нийт хөрөнгө	10,494,390.7	13,928,324.1	3,433,933.3
Өр төлбөр	120,424.8	162,213.5	41,788.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10,373,965.9	13,766,110.6	3,392,144.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10,494,390.7	13,928,324.1	3,433,933.3

Бараа материалын эхний үлдэгдэл 438,138.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 541,003.4 мянган төгрөг болж 102,869.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст худалдан авсан 299,298.7 мянган төгрөгийн ковидын оношлуур, эм боох материал, 116,192.8 мянган төгрөгийн хангамжийн материал, 114,270.9 мянган төгрөгийн хүнсний материал, 85,779.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг худалдан авснаас шалтгаалжээ.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 37,738.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 3,196,930.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 37,781.5 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 13,766,110.5 мянган төгрөг болж 3,392,144.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,544,541.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 4,544,541.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын хүргүүлсэн төсвийн төслөөс 136,913.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж Заамар сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн сумын 2021 оны төсөв батлах тухай 05 дугаар тогтоолд 4,681,454.3 мянган төгрөгөөр баталсан байна. Заамар сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн төсөв батлах тухай 06 дугаар тогтоолд 180,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Заамар сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн орон нутгийн төсөв батлах тухай 02 дугаар тогтоолд зааснаар 281,114.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 4,962,568.6 мянган төгрөгөөр төсвийг тодотгон баталсан байна.

Тайлант онд Заамар сумын Засаг даргын тодотгон баталсан төсвөөс Орон нутгийн хөгжлийн сангийн 116,248.3 мянган төгрөгийг төсвийн хуваарьт оруулаагүй орхигдуулснаас 4,846,320.3 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар болсон байна.

Тайлант онд Заамар сумын Засаг даргын захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 4,846,320.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 4,206,527.5 мянган төгрөгийг бараа үйлчилгээний урсгал зардалд, хувийн хэвшилд олгох татаас 30,228.0 мянган төгрөг, 361,800.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, урсгал шилжүүлгийн зардалд 67,764.8 мянган төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлд 180,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 3,433,172.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 991,950.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 58,656.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 362,540.6 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,309,725.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,033,947.3 мянган төгрөг, 69,027.1 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 128,749.8 мянган төгрөгийг нийт 4,541,449.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч урьд оны үлдэгдлээс 182,500.0 мянган төгрөгийн санхүүжилт ирээгүй, СХС-д 52,219.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгож, 123,447.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,178,236.0 мянган төгрөг буюу 86.2 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардал 98,056.1 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 47,353.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 343.3 мянган төгрөг, нормативт зардал 61,102.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 23.0 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 3,041.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 10,270.2 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 991.4 мянган төгрөгийн зардлууд хэмнэсэн нь шалтгаалсан байна. Үүнд: Ковид-19 өвчлөлтэй холбоотойгоор томилолтоор ажиллаагүй, сургууль, цэцэрлэг ажиллаагүйгээс үдийн цай хөтөлбөр хэрэгжээгүй, илүү цагийн хөлс олгоогүй зэргээс шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 123,447.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээнд 361,800.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 27,343.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Энэ нь Засгийн газрын 43 дугаар тогтоол гарснаас хойш тендер зарлаагүйгээс шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 324,490.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 23,926.9 мянган төгрөг, эрүүл

мэндийн даатгалын сангаас нэмэлт орлого 222,857.7 мянган төгрөг, хандив тусламжаар 30,004.4 мянган төгрөг нийт 601,279.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс байр ашиглахтай холбоотой зардалд 9,637.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 26,765.6 мянган төгрөг, нормативт зардал 159,805.1 мянган төгрөг, эд хогшлын зардалд 36,745.6 мянган төгрөг, томилолтын зардалд 297.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 1,396.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 36,988.9 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмж 43,139.8 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 29,016.9 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 214,344.5 мянган төгрөг олгож, нийт 558,138.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 16,976.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, хөрөнгийн зардалд 5,996.0 мянган төгрөг зарцуулж 20,168.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Заамар суманд тайлант онд 2,353,134.0 мянган төгрөгийн өртөгтэй Шижир алтны хүүхдийн цэцэрлэг, 196,200.0 мянган төгрөгийн үнэтэй Халзангийн давааны 6.8 км сайжруулсан зам, 240,712.0 мянган төгрөгийн Заамар парк цэцэрлэгт хүрээлэн ашиглалтад орсон байна.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн харьяа байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, БНСБС, ОНХС, СХС-ийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ИТХ, ЗДТГ, Соёлын төвийн санхүүгийн тайланд 45,336.0 мянган төгрөгийн залруулга хийгдэж, 5,200.0 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт, 35,748.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 13,263.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөн.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, эмийн эргэлтийн сан гэсэн 6 санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан. Аудитаар ЕБ-ийн дунд, бага сургуулийн санхүүгийн тайланд 3,966.0 мянган төгрөгийн залруулга хийгдэж, 8,961.8 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 8,882.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 2 зөвлөмж, Төвийн болон Шижир алтны цэцэрлэгийн санхүүгийн тайланд 17,071.4 мянган төгрөгийн залруулга хийгдэж, 20,035.1 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 4,068.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 2 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 490,425.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 9,578.7 мянган төгрөгийн албан шаардлага, 213.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээлэл, мэдээлээгүй 2 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 12, зарлагын 8 гүйлгээ байршуулж, 5,0 саяас дээших худалдан авалтын 32 гүйлгээ байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар хууль тогтоомжтой холбоотой, орон нутгийн орлого бүрдүүлэлтэй холбоотой 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Заамар сумын Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 1/206 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 509,306.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 509,306.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхтэй холбоотой асуудал
Илрүүлэлт:

Төв аймгийн Заамар сумын сумын Засаг дарга улсад төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 3,118.0 мянган төгрөгөөр, аймагт төвлөрүүлэх 1 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 357,208.8 мянган төгрөгөөр, орон нутагт төвлөрүүлэх 1 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 136,368.7 мянган төгрөгөөр тасалсан байна. Учир нь Заамар сумын аймагт төвлөрүүлэх газрын төлбөрийн орлого 357,208.8 мянган төгрөгөөр тасарсан нь хэт өндөр буруу төлөвлөсөн, Шинэ Зеландын хөрөнгө оруулалттай Уулс заамар ХХК ковид-19 цар тахал гарч үйл ажиллагаа явуулаагүй тасалдсан учраас орон нутагт төвлөрүүлэх суутган-2 136,236.8 мянган төгрөгөөр тасарсан нь шалтгаалжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: 3 шатны орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх, орлогыг үндэслэлтэй төлөвлөх.

2.Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

ИТХ тайлант онд сургалтын хэрэглэгдэхүүн, ном, сургалт, хоолны зардалд 1,612.5 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.

3.Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт

Соёлын төв тайлант онд худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 10,998.2 мянган төгрөгийн 3 байгууллагын гүйлгээ е баримтаар баталгаажгаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар Татварын нэгдсэн системд баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Засаг дарга	1	496,695.5	0	0.00	0	0	0	0	1	496,695.50
2	Ерөнхий боловсролын сургууль	6	13,390.8	1	3,966.0	3	8449,4888	1	975.3	1	
3	Шижир алт бага сургууль	3	8,420.3	0	-	1	513.3	1	7,907.0	1	
4	Хүүхдийн цэцэрлэг	5	24,243.5	1	12,600.0	2	8,075.4	1	3,568.2	1	
5	Шижир алт хүүхдийн цэцэрлэг	5	16,931.1	1	4,471.4	2	11,959.7	1	500.0	1	
6	Соёлын төв	1	10,998.3	0	-	0	0.0	0	-	1	10,998.3
7	Эрүүл мэндийн төв	3	500,003.8	1	490,425.1	0	0.0	1	9,578.7	1	
8	Сум хөгжүүлэх сан	2	61,873.8	0	-	0	0.0	1	61,704.9	1	169.0
9	Заамар сумын ОНХС	2	10,030.2	0	-	0	0.0	0	-	2	10,030.2
10	Эмийн эргэлтийн сан	1	213.0	0	-	0	0.0	0	-	1	213.0
11	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан	0	0.0	0	-	0	0.0	0	-	0	-
12	Засаг даргын тамгын газрын дарга	5	82,224.4	1	40,623.3	1	5,200.0	2	35,748.0	1	653.0
13	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	6,325.3	1	4,712.7	0	0.0	0	-	1	1,612.6
Дүн		36	1,231,349.9	6	556,798.5	9	34197.864	8	119,982.0	13	520,371.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Ерөнхий боловсролын сургууль	1	1,197,458.4							1	1,197,458.4
1	Шижир алт бага сургууль	1	674,791.3							1	674,791.3
2	Хүүхдийн цэцэрлэг	1	462,608.5							1	462,608.5
3	Шижир алт хүүхдийн цэцэрлэг	1	468,621.0							1	468,621.0
4	Эрүүл мэндийн төв	1	1,732,381.9							1	1,732,381.9
Дүн		5	4,535,861.1							5	4,535,861.1
Нийт дүн		41	5,767,211.0	6	556,798.5	9	34,197.9	8	119,982.0	25	5,056,232.6

6.Санал дүгнэлт өгсөн байгууллага

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

№	Байгууллагын нэр	Санал дүгнэлтийн хэлбэр				
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	Дүн
1	Засаг даргын тамгын газар	1				1
2	Ерөнхий боловсролын сургууль	1				1
3	Шижир алт бага сургууль	1				1
4	Хүүхдийн цэцэрлэг	1				1
5	Шижир алт хүүхдийн цэцэрлэг	1				1
6	Эрүүл мэндийн төв	1				1
	Дүн	6				6